

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ 5 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

Нэг. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Ажлын албанаас 2019 оны 05 дугаар сард ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1 удаа болж, 8 асуудал хэлэлцэн 4 тогтоол гарч, 4 тэмдэглэлээр үүрэг өгөв. **Тэргүүлэгчдийн VII хуралдаанаар:**

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Арван гуравдугаар хуралдааныг 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдуулахаар товыг тогтоож 4 асуудал хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

2. Монгол Улсын Төв аймгийн ИТХ, БНСВУ-ын Хоа Бинь мужийн Үндэсний Ассемблейн хооронд байгуулсан “Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд Хоа Бинь мужийн Ардын зөвлөлийн дарга Чан Танг Нинь тэргүүтэй зочид төлөөлөгчдийг хүлээн авах арга хэмжээний бэлтгэл, зохион байгуулалыг хангах ажлын хэсгийг байгууллаа.

3. Сумдад 2019 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоог 45 –аар тогтоож, тэдгээрийн цугларалтын үеийн хувийн бэлтгэлийн нормативын жагсаалтыг баталсан. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийн бэлтгэлийг хангуулж, сургалт сурталчилгаа зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авах үүргийг аймгийн Засаг даргад өгөв.

4. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцээд 10 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч, “Үр дүнгүй” үнэлэгдсэн ажлын байрнаас ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх судалгаа хийж, анхан шатанд ажиллаж байгаа эмч нарын мэргэжлийн түвшин, ур чадварт нэгдсэн аттестатчилал явуулж, үр дүнг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг аймгийн засаг даргад даалган тэмдэглэлээр үүрэг өгсөн.

5. Аймгаас Залуучуудын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай мэдээллийг хэлэлцээд төрийн болон аж ахуй нэгж, байгууллагын дэргэд залуучуудын асуудал хариуцсан орон тооны бус зөвлөлийг байгуулах, залуу албан хаагч, ажилчдыг нийгэмд тустай үйл ажиллагаа, төрөл бүрийн төсөл, хөтөлбөрт хамруулах зэрэг ажлуудыг эрчимжүүлж, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эко тохилог хашаа төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор сумын төв, суурин газар бүрт 2-оос доошгүй шинэ, залуу гэр бүлийн хашааг загварын дагуу тохижуулж бусдад туршлага, дууриалал болгох үүрэг өгсөн.

6. Батсүмбэр сумын Үдлэг, Жаргалант сумын Жаргалант, Борнуур сумын Борнуурын услалтын системүүдийн өнөөгийн байдал, цаашдын ашиглалтын тухай асуудлыг хэлэлцээд одоогийн өмчлөл, эзэмшил, засвар, шинэчлэл хийхэд шаардагдах хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх боломж, цаашид хэрхэн үр өгөөжтэй ашиглах талаар санал боловсруулж, 8 дугаар хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргад даалгасан.

7. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангийн тухай асуудлыг хэлэлцээд “Шилэн дансны тухай” хуулийг иргэдэд сурталчлах ажлыг өргөжүүлж, төсвийн гүйцэтгэл, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдалд олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх, цахим хуудсанд тавьж буй мэдээллүүдийн үнэн зөв, нийтэд ойлгомжтой байдалд судалгаа дүгнэлт хийж, нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнд хүргэхийг аймгийн Засаг даргад даалгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хяналтын Хороо, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөв.

8. Монгол улсад Атар газар эзэмшиж газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэй бие даасан салбар болгон хөгжүүлсний түүхт 60 жилийн ой, Төв аймгийн Архуст сум байгуулагдсны 60, Баянцогт сум байгуулагдсны 90 жилийн ойг тохиолдуулан хөдөө аж ахуй, боловсролын салбарын хөгжилд авъяас билэг, хүч хөдөлмөрөө дайчлан олон жил, үр бүтээлтэй ажилласан, залуу хойч үеийг өөрийн арга туршлагаар залгамжлан хүмүүжүүлж байгаа 54 иргэнийг төрийн дээд одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлалаа.

Аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2019-2020 оны төлөвлөгөө”-ний төсөлд иргэдээс санал авах хэлэлцүүлгийг зохион Зуунмод суманд байгуулахад 60 гаруй иргэн оролцож, санал хүсэлтээ илэрхийллээ.

2019 оны 5 дугаар сарын 21-26-ны өдрүүдэд Дорноговь аймагт зохион байгуулагдсан “Төвийн бүсийн аймгуудын ИТХ-ын Ажлын албаны ажилтнуудын зөвлөлдөх уулзалт”-ад бүрэн хамрагдсан.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: 2019 оны 05 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж, 16 асуудлыг хэлэлцэн холбодох шийдвэрийг гарган ажилласан.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу 30 сая төгрөгийн өртөг бүхий “Явуулын багийн тоног төхөөрөмж”-ийг хүлээн авсан бөгөөд 2019 оны 2 дугаар улиралд багтаан 5 суманд хүргэхээр төлөвлөж байна.

Аймгийн Музейгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, түүнийг дагаж мөрдөх дүрэм журам” сэдвийн хүрээнд 12 албан хаагчид анхан шатны ойлголт өгөх сургалт явууллаа.

2019 оны 05 дугаар сарын 29-ний байдлаар Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 165 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дээд шатны яам, агентлагт уламжилсан. Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 38 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 51 иргэнийг шагнаж, урамшууллаа.

“Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын 3.1.1, аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/718 захирамжаар баталсан хуваарийн дагуу “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга иргэдийн санал, хүсэлтийг Лхагва гараг бүрийн 10:00-13:00 цагийн хооронд хүлээн авч шийдвэрлэдэг болсон. Энэ ажлын хүрээнд 2019 оны эхний 5 сарын байдлаар 20 удаагийн уулзалт зохион байгуулахад давхардсан тоогоор 120 иргэн 232 санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл, асуулт гаргасан байна.

Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын удирдах ажилтны нэгдсэн шуурхайг 2 удаа зохион байгуулж, 43 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

2019 оны 5 дугаар сард сум, байгууллагуудад 5 удаа цахим сургалт хийж, зөвлөмж зааварчилгаа өгсөн. Танхимын 8 удаагийн хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын хэвийн ажиллагааг хангасан.

Аймгийн ЗДТГ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс дараах хууль тогтоомж, зааварчилгаагаар эмхэтгэл, зурагт үзүүлэн бэлтгэн хэлтэс, нэгж, албан хаагчдад танилцуулсан.

Хууль тогтоомж:	Зааварчилгаа:
Хөдөлмөрийн тухай хууль /хэсэгчлэн авсан/	Оффисын ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

ХАБЭА-н тухай хууль	Албан томилолтын үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
ХАБЭА-н үндэсний 5 дахь хөтөлбөр	Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
ХАБЭА-н зөвлөл ажиллуулах тухай Хөдөлмөрийн сайдын тушаал	Жолоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм	Мужааны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Төрийн албаны стандартын хүрээнд: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын дагуу аймгийн хэмжээнд 27 сумын ЗДТГ-ын 12 албан тушаалын, 10 байгууллагын 129 албан тушаалын тодорхойлолтын төслийг хянан ТАЗ-д хүргүүлэв. Мөн төрийн байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын судалгаа авах ажлыг зохион байгуулж, дүнг ТАЗ-д хүргүүллээ.

Мал аж ахуйн хаваржилт, мал төлөлтийн эхэлсэнтэй холбогдуулан төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор мал бүхий албан хаагчдад ажлын 3-5 хоногийн цалинтай чөлөө олгож, ар гэртээ дэмжлэг үзүүлэх чиглэлийг төсөвт байгууллагуудад хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд 9 сум, 5 байгууллагын 53 төрийн хаагчид чөлөө олгосноор нийт 950 ямаа самнаж, 1100 төл хүлээн авч, 55.2 сая төгрөгийн хөдөлмөрийн дэмжлэг үзүүлсэн байна.

ТАЗСЗ-өөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны "ТАЗСЗ" цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2019.05.29-ний байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	8
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	1
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	-
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар	-
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	-
НИЙТ ДҮН		9

2019 оны 05 дугаар сарын 29-ний байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэр лэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Албан бичиг	155	18	17	1	-
2	Өргөдөл, гомдол	20	20	18	2	-

Тайлант хугацаанд салбар зөвлөлөөс 30 албан бичиг гадагш явуулсан.

Гадаад харилцаа: Аймгийн шууд харилцаат БНСУ-ын Кангвон мужид 2019 оны 7 дугаар сарын 25-аас 28-ны өдрүүдэд зохион байгуулагдах Гангнюны Олон улсын хүүхдийн 18 дахь удаагийн урлагийн их наадамд Мөнгөнморьт сумын ЕБС-ийн "Бөртэ" хамтлагийг оролцуулахаар бэлтгэл хангаж байна.

Шууд харилцаат БНСУ-ын Кангвон мужийн Хөдөө аж ахуйн техник технологи, Эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй "Зуунмод агропарк" төслийн хүрээнд ирүүлсэн 300,0 гаруй сая төгрөгийн бараа материалыг хүлээн авав. Хүлэмжийн барилгын ажил 60 гаруй хувьтай байна.

Зүүн Хойд Азийн орнуудын харилцаат бүс нутгуудын Засаг захиргааны харилцаа хамтын ажиллагааны Дээд хэмжээний уулзалт 24 дэх удаагийн Саммитын Бэлтгэл ажлын

зөвлөгөөнийг 2019 оны 5 дугаар сарын 16-нд Төв аймагт амжилттай зохион байгууллаа. Зөвлөгөөнд Төв аймаг, БНСУ-ын Кангвон, БНХАУ-ын Жилинь муж, Япон улсын Тоттори муж, ОХУ-ын Приморын хязгаарын нийт 22 төлөөлөгч оролцов.

БНСУ-ын Кангвон мужийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Кангвон мужийн Галын алба хамтран аймгийн Онцгой байдлын газарт хандивласан гал унтраах 2 авто машиныг хүлээн авлаа.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2019 оны 05 дугаар сарын 28-ны байдлаар Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 26 байгууллага 330 гаруй төрлийн үйлчилгээг 8400 орчим иргэнд, өдөрт дунджаар 350 иргэнд шуурхай хүргэн ажиллаа.

Аймгийн веб сайтад **23**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **52** мэдээ мэдээлэл нийтлэгдсэн. 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **4** дугаар, мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар давтагдсан тоогоор нийт **70** мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэлээ.

7027-1111 нээлттэй утсанд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой 16 гомдол санал ирснийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэв.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: Эрүүл мэнд, боловсрол, соёл, хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, дэд бүтцийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ 52, төлөвлөгөөт бус шалгалт 3, хяналт шинжилгээ 2, урьдчилан сэргийлэх хяналт 4, тандалт судалгаа 3 тус тус хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага 44, акт 8, зөвлөмж 16, дүгнэлт 12 үйлдэж, иргэн аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. 4 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 1800 нэгжийн торгуулийн арга хэмжээ ногдуулав.

Төрийн өндөр албан тушаалтны ажлын айлчлалын үеийн хоололтод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Төв аймгийн Эрдэнэ сумын 13-р зуун цогцолборт Пижи, Микронез улсын парламентийн дарга, бусад зочид төлөөлөгч нарын нийт 13 хүний хооллолтод урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Нийтийг хамарсан баяр ёслолыг зохион байгуулах нэгдсэн арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хүнсний худалдааны газар-27, нийтийн хоол үйлдвэрлэлийн газар-25, нийт 52 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан. “Хүүхдийн баяр”-ийн бэлэг сонгоход анхаарах асуудлаар сургалтыг зохион байгуулсан.

Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны шийдвэрээр Сэргэлэн сумын нутагт үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА-н чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд үзлэг хийсэн.

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой хими, микробиологийн аргаар хэрхэн тэмцэх талаар зөвлөмж гарган 27 суманд хүргүүлэв.

Хустайн байгалийн цогцолборт газрын захиргаатай хамтран 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр тус жуулчын баазын холбогдох албан тушаалтан, Алтанбулаг, Аргалант, Баянхангай сумдын гадаад орны жуулчин хүлээн авах малчдын бүлгийн нийт 29 хүнд “Эрүүл ахуйн зохистой дадал” сэдвээр сургалтыг зохион байгуулсан.

Итгэмжлэгдсэн лаборатори нь төлөвлөгөөт хяналт шалгалт, ААН, иргэний хүсэлтийн хүрээнд 261 сорьц хүлээн авч, 1471 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэж, үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон. Шинжилгээгээр 48 сорьц 63 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй гарсан.

Онцгой байдлын газрын хүрээнд: Албаны 15 жилийн ойг угтан, Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх зорилт дэвшүүлж, газрын нийт бие бүрэлдэхүүн 15 бүтээлч ажил өрнүүлж замын цутгалт, газрын болон спорт заалны гадна өнгө үзэмжийг сайжруулан засварлаж байна.

Мөнгөнморьт суманд Гал түймэр унтраах анги, Баян, Лүн суманд Эрэн хайх, аврах бүлэг байгуулагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн алба хаагчдыг томилж, анги, бүлгийн байр гадна талбайг тохижуулж, 06 дугаар сарын 20-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.

Газрын ёс зүйн алба 1 удаа хуралдаж, ёс зүйн зөрчил гаргасан 3 алба хаагчийн асуудлыг хэлэлцлээ.

Баянжаргалан суманд Зүүн бүсийн 7 сумыг хамруулан 2019 оны 05 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийг зохион байгуулан явуулж, аймгийн Засаг даргын захирамжаар 2.0 сая төгрөгийн зардал гаргасан. Тус сургуульд Баянжаргалан сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн 7 бүлгийн 64 албан хаагч, Эрдэнэ, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Архуст, Баян, Баянцагаан сумдын Засаг дарга, ЗДТГ Дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, МЭҮТасгийн дарга, Багийн Засаг дарга, жолооч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр нийт 36 албан хаагч, 6 техниктэй оролцлоо. Мөн Баянжаргалан сумын Засаг даргын А/61 дүгээр захирамжаар 11 алба хаагчийн ажлын хэсэг байгуулан “Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа” хийхэд Аюулын индекс 54.375, Өртөнгийн индекс 38.375, Эмзэг байдлын индекс 51.5, Чадавхийн индекс 67.375, нийт эрсдэлийн индекс 24.181 буюу “Ногоон өнгө”-тэй үйл ажиллагааг бататгаж, сайжруулах шаардлагатай гэсэн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан хяналт шалгалтын удирдамжийн дагуу Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Мак” хийт бетоны үйлдвэр, Ясны үйлдвэр, Мөөгний үйлдвэр, Хуванцар савны үйлдвэр зэрэг 4 байгууллагад шалгалт явуулж, гал түймэр, гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 27 зөрчил илрүүлж, улсын хяналтын байцаагчийн ЗБАШ-4-ийг бичиж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 21 байгууллага, аж ахуйн нэгжид ажиллаж, гамшиг осол, гал түймэр гарч болзошгүй 131 зөрчил дутагдлыг илрүүлэн газар дээр нь 42 зөрчлийг засуулж, 89 зөрчилд улсын хяналтын байцаагчийн албан шаардлага 15-ыг бичиж холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

Галын аюулгүй байдал нь хангагдсан аж ахуй нэгж, байгууллагад 34 ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож, 1 барилга байгууламжийн ажлын зургийг хянасан.

Батсүмбэр, Мөнгөнморьт сум дахь Гал түймэр унтраах анги, Лүн, Баян сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн алба хаагч нарт “Хээрийн түймэр унтраах дадлага, сургууль”-ийг 2019 оны 05 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Сэргэлэн сумын Өндөр дов гэх газар зохион байгууллаа.

Ой, хээрийн гал түймэр: 1. Эрдэнэ суманд ой хээрийн түймэр 1 удаа гарч, 282 га талбай шатаж, гал түймрийг унтраахад Онцгой байдлын албанаас 14 албан хаагч 2 техник, Орон нутгаас 34 хүн, 3 техниктэй ажиллаж, гал түймрийг бүрэн унтраасан байна.

2. Батсүмбэр суманд ой хээрийн түймэр 1 удаа гарч, 11 га талбай шатаж, гал түймрийг унтраахад Онцгой байдлын албанаас 2 албан хаагч, Орон нутгаас 40 хүн, 5 техниктэй ажиллаж, гал түймрийг бүрэн унтраасан байна.

Объектын гал: 1. 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Зуунмод сум Номт /1 дүгээр/ багийн нутаг, Мэргэжлийн хяналтын газрын барилгын хажууд гал тогооны зориулалттай 4 ханатай гэр шатсан бөгөөд хохирол тооцоогүй болно.

2. 05 дугаар сарын 09-ний өдөр Баян сумын 2 дугаар багийн нутаг, Дэлгэрийн цагаан өндөр гэх газар Өвөлжөө саравч шатаж хувийн өмчид 1,350,000 төгрөгийн хохирол учирсан болно.

3. 05 дугаар сарын 09-ний өдөр Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг 11-7 тоотод 700 боодол өвс шатсан бөгөөд Цагдаагийн байгууллагаар шалгагдаагүй болно.

4. 05 дугаар сарын 12-ны өдөр Эрдэнэ сумын Баянтуул 3 дугаар багийн нутаг Баруун баян гэх газар иргэн Л.Чойжилын эзэмшлийн 4 ханатай гэр бүрэн шатсан байна. Цагдаагийн байгууллагаар шалгагдаагүй болно.

5. 05 дугаар сарын 22-ны өдөр Баянчандмань сумын Замт 2 дугаар багийн нутаг Илтийн 10-7 тоотод иргэн Д.Болдбаатарын эзэмшлийн 5 ханатай гэр, эд зүйлийн хамт шатаж хувийн өмчид 1,260,000 төгрөгийн хохирол учирсан.

6. 05 дугаар сарын 24-ний өдөр Баянчандмань сумын Замт 3 дугаар багийн нутагт Замтын булаг гэх газар иргэн Ж.Пүрэвсүрэнгийн эзэмшлийн 5х6 хэмжээтэй уурын зуухны барилга шатсөн бөгөөд Цагдаагийн байгууллага шалгагдаж байна.

7. 05 дугаар сарын 24-ний өдөр Батсүмбэр сумын Цогт-Өндөр 2 дугаар багийн нутагт Баян буурал гэх газар иргэн Б.Энхтуяагийн эзэмшлийн 6х8 хэмжээтэй Дүнзэн байшин шатсан бөгөөд Цагдаагийн байгууллагад шалгагдаж байна.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Хууль сурталчлах сарын ажлын хүрээнд 5 сард “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Архивын тухай”, “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хуулиуд болон холбогдох дүрэм журмыг сурталчлах 10 хоногийн аяныг аймаг, сум, байгууллагуудын хэмжээнд зохион байгуулав.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 5 сарын дугааруудыг бэлтгэн нийтэд хүргэсэн.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 54 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянан зөвлөгөө өгсөн. Мөн 59 иргэ, байгууллагад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа өгч, эрх зүйн туслалцаа үзүүлэв.

Аймгийн төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудаас сүүлийн 20 жилд гаргасан хүчин төгөлдөр, нийтэд хамааралтай захиргааны шийдвэрүүдийн жагсаалтыг гаргаж, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд аймгийн Засаг даргыг төлөөлж 5 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон.

Хуульчдын холбооны Төв аймаг дахь салбартай хамтран 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хууль хяналтын байгууллагуудын “Нэгдсэн өдөрлөг”-ийг зохион байгуулахад 150 гаруй иргэнд хууль, зүйн зөвлөгөө өгч, 14 иргэнд архивын лавлагаа, 5 иргэнд өмгөөллийн үйл ажиллагаа үзүүлж, 450 гаруй гарын авлага, материалыг иргэдэд тараасан байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 11 зорилт 65 хэрэгжүүлэх арга хэмжээтэй төлөвлөж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Аймгийн ИТХ-ын Нутгийн удирдлага, хууль хяналт, гадаад хамтын ажиллагааны хороотой хамтран 2019 оны 05 дугаар сарын 17-ний өдөр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулахад Зуунмод сумын 6 багийн 85 иргэн оролцсон.

“Аймгийн нутаг дэвсгэрт шашны сүм хийд байгуулахад зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг шинэчлэх ажлын хүрээнд “Нээлттэй хэлэлцүүлэг”-ийг 05 дугаар сарын 29-ний өдөр 27 суманд зохион байгуулж, иргэд, сүсэгтнүүд, шашны сүм, хийд, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцууллаа. Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар “Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд байгуулах, үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, цуцлах үйл ажиллагааг зогсоох, хяналт тавих журам”-ын төсөл, Батсүмбэр, Зуунмод, Дэлгэрхаан суманд Буддын хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн 3 иргэний хүсэлтийг тус тус хэлэлцүүлээ.

Архивын үйлчилгээ: “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийг угтаж 27 сум, төрийн байгууллагуудын дарга,

бичиг хэргийн ажилтан нарт танхимаар 4 удаа, цахимаар 2 удаа тус тус сургалт явуулж, арга зүйн зөвлөгөө өгч, 6 суманд зөвлөн туслав. Мөн улсын үзлэг утгсан урьдчилсан үзлэгийг аймгийн 27 сум, төсөвт 32 байгууллагыг хамруулан зохион байгуулж, зөвлөмж чиглэлээр ханган хугацаатай үүрэг өглөө.

Тайлант хугацаанд архивын эх баримтаас 124 иргэний хүсэлтээр 263 хуулбар хувь, 80 лавлагаа гарган үйлчилсэн бөгөөд 618.800 төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэв.

2 хөмрөгийн 254 хадгаламжийн нэгжийн 3012 хуудас баримтын 13765 хүний нэр, 2728 заалтын тоо, 2728 тушаалын тоон мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж PDF.JPEG хэлбэрт хувиргав. Мөн 2 хөмрөгийн 47 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийсэн.

Улсын бүртгэлийн үйлчилгээ: 2019 оны 05 дугаар сарын байдлаар эд хөрөнгийн бүртгэлийн цахим санд нийт 49959 хувийн хэрэг байгаагаас үл хөдлөх /газраас бусад/ - 9488, Газар өмчлөх эрхийн -40471 хувийн хэрэг байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 18473. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомжийн дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 84212782 төгрөг, үл хөдлөх худалдан борлуулсны орлогоос 42456741 төгрөг, тэмдэгтийн хураамжаас 2484734 төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

Тайлант хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 113 аж ахуй нэгж, байгууллага бүртгүүлж, 83 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 17, хууль хяналтын байгууллагад 32 лавлагаа мэдээлэл өгч, 580500 төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт орууллаа.

Цагдаагийн газрын ажил ажиллагааны хүрээнд: “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зорилгоор “Нэг хором”, “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр “Байгалиа хамгаалъя”, “Залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, хүүхдийн хүмүүжил төлөвшилд эцэг эх, асран хамгаалагч нарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх “Зөв тусгал”, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал”, “Мотоцикль” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, аянуудыг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулав. Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, аяны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын 1600 ажилтан, албан хаагч нарт, Ерөнхий боловсролын дунд сургуулийн 6380 сурагчдад “Зөв тусгал” сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна.

Гудамж талбай, олон нийтийн газар болон гэр орон, ахуйн хүрээндээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгслэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон, шүүхээр баривчлагдсан, албадан саатуулагдсан 110 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд хүлээн авснаас эрүүлжүүлэгдсэн 48, албадан саатуулсан 9, шүүхээр баривчлагдсан 53 иргэнийг код журмийн дагуу биед болон эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авсан. Саатуулах байрны эмч нар 7 иргэнд эмнэлгийн анхны тусламжийг үзүүлж, ар гэр, асран хамгаалагчид нь 12 иргэнийг хүлээлгэн өгөв. Эрүүлжүүлэгдсэн 48 иргэний төлбөр 199200 төгрөг, хугацаа дууссан 41 хүмүүжигчээс, төлбөрийн чадвартай 36 иргэний төлбөр 1375600, төлбөрийн чадваргүй 5 иргэнийг багийн Засаг даргын тодорхойлолтоор хааж, нийт 1574800 төгрөгийг төрийн сангийн дансанд 100 хувь тушаасан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 56 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 15 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, ЦЕГ-ын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг

бүртгэсэн. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5803 жолоочийг 167,990,000 төгрөгөөр торгов.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Тайлант хугацаанд Криминалистикийн шинжилгээ-96, магадлан шинжилгээ-74, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-216, гарын мөрийн санг баяжуулсан-78, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 326 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
5 дугаар сар	398	236	11	623	222	401	35.6%
	3920610.2	2301951.2	531308.2	5691253.2	1159291.7	4531961.5	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр:

Газар тариалан: Газар тариалангийн бодлого, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаах мэдээлэл өгөх зорилгоор “Газар тариалангийн зөвлөгөөн”-ийг Баянцогт, Батсүмбэр, Жаргалант, Эрдэнэсант суманд зохион байгуулж, 80 аж ахуй нэгж, 230 иргэнийг хамруулав.

Хаврын тариалалт 5 дугаар сарын байдлаар:

- Үр тариа 33667 га буюу 37 хувьтай, үүнээс улаан буудай 33091га 36,6 хувьтай,
- Тосны ургамал 1050 га
- Төмс 5294,7 га буюу 88 хувьтай,
- Хүнсний ногоо 306,4 га-д тариалж 26 хувьтай байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас хүнсний ногооны 80 кг үр авч сумдад хуваарилах ажлыг зохион байгуулсан.

Зуунмод сумын Соёл амралтын хүрээлэнд “Хүлэмжийн цогцолбор парк” байгуулах бүтээн байгуулалтын ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мал аж ахуй: Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Буян ус” ХХК нь Алтанбулаг суманд 2, Баян 2, Сэргэлэн 1 худаг тус тус гаргасан. “Усны барилга”ХХК нь Борнуур суманд 1, Сүмбэр суманд 1 худаг гаргах хайгуулын ажлыг хийлээ.

Оны эхний төллөх насны малын 78% нь буюу 1707190 толгой мал төллөж, гарсан төлийн 98.9% нь буюу 1694225 толгой төл бойжиж байна. Гарсан төлийн 1.1% нь буюу 19636 толгой төл, том мал 10837 буюу нийт малын 0.2% нь хорогдоод байна.

Баян-Өнжүүл, Бүрэн сумын малчид, мал бүхий иргэдэд хурга,бярүүг цахилгаан соронзон долгионы аргаар төөнөж хөнгөлөх аргыг танилцуулж 2 сумын 8 малчны 300 хургыг хөнгөлөх ажлыг зохион байгууллаа.

Үйлдвэрлэл, үйлчилгээ: Аймгийн Засаг даргын 2019 оны А/292 тоот захирамжаар “Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэг”-ийг 27 суманд зохион байгуулж, 2011-2018 оны сангийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, дүнг нэгтгэх ажил хийгдэж байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах аймгийн дэд хороог байгуулж, шинэчилсэн журамтай танилцах сургалтад хамрагдсан.

Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамтран “Мал төхөөрөмж, мах боловсруулах үйлдвэрт эрүүл ахуйн зохистой дадал, хүнсний аюулгүй байдлын хяналт

шинжилгээ, эрүүл ахуйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх” сургалтад “Баяндэлгэр Хүнс” ХХК-ийн 14 ажилтныг хамруулж, ур чадварыг дээшлүүллээ.

Мал эмнэлгийн үйлчилгээ: “Шөвөг яр” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 27 сумын 94 мал эмнэлэгийн нэгжид хуваарилан олгосноор 185.6 мянган толгой төл мал хамруулсан байна. Нийт вакцинжуулалт 23.4 хувьтай ба 31 удаагийн дуудлагаар мал эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлжээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний ариун цэвэр эрүүл ахуйн хяналт тавих удирдамжийн дагуу Зуунмод сумын Хүнсний дэлгүүр, Худалдааны төвүүдэд худалдаалагдаж буй өндгөнд овоскопын шинжилгээ, сүүнд бруцеллёзын шинжилгээ, маханд шинэлэг байдал, амин шүвтрийн азот, Ph зэрэг технологи, эрүүл ахуй аюулгүй байдлын анхан шатны магадлан шинжилгээ хийж, зөвлөгөө мэдээлэлээр ханган ажилласан.

Лүн сумын МЭХЦХЦ-ийн хяналтын цэг нь тэмээ 101, адуу 805, үхэр 173, хонь 3690, ямаа 260 толгой, мах, махан бүтээгдэхүүн 153,8 тн, арьс шир 7900 ширхэг, ноолуур 57,5 тн, ноос 26 тн зэрэг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгосон байдлыг шалгаж, 344 авто машин, 264 м² талбайд ариутгал халдваргүйтэл хийж, 16 зөрчилтэй тээврийг хэрэгслийг илрүүлэн зохих арга хэмжээ авсан.

Хөрөнгө оруулалт, Худалдан авах ажиллагааны үйлчилгээ:

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 41784.1 сая төгрөгийн 69 төсөл арга хэмжээнд тендер шалгаруулалт зохион байгуулахаас 37931.6 сая төгрөгийн 51 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж хэрэгжилт 72 хувьтай байна.

“Тогтвортой Амьжиргаа-3” төслийн хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны А-3 гэрчилгээ олгох сургалтыг 168 иргэн, албан хаагчдад хийсэн.

Орон нутгийн өмчит 223 байгууллагын өмчийн тайлан нэгтгэл, 166 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний нэгтгэлийг хийж ТӨБЗГ-т нэгтгүүлж, дүнг Аймгийн Засаг даргын Зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв.

“Томоко” ОНӨААҮГ-ыг хамтарсан үйлдвэрийн газар байгуулах замаар хувьчлах шийдвэрийн хүрээнд иргэн Т.Баярхүүтэй харилцан тохиролцсоноор “Шимт органик бордоо” ОНӨО ХХК-ийг аймгийн Засаг даргын 2019 оны А/283 тоот захирамжаар үүсгэн байгуулсан.

Зуунмод сумын 1-р багийн Тээвэрчдийн гудамжны “Соёл хотхон”-ы 400-р байрны 54 айлын орон сууцнаас түрээсийн хөтөлбөрт хамрагдан худалдан авалт хийсэн 11 орон сууцны хэмжилт хийх ажлыг “Орон сууцны барилгын доторх талбайн тооцох аргачлал” MNS 6058:2009 стандартын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2019 оны А/236 тоот захирамжаар “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Монголын үнэн сонины 2019.05.16-ны дугаарт БАМ-ын 31, 32, 33-р байр, 5-р байр, 3, 4-р байр, 15-р байр, Мал эмнэлэг, үржлийн байр зэрэг 5 байршлын орон сууцны дахин төлөвлөлтийн гүйцэтгэгчийг шалгаруулахаар төсөл зарлагдсан.

Сумын төвийн ундны эх үүсвэрийн цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах /Баянчандмань, Эрдэнэ, Цээл, Заамар, Дэлгэрхаан/ ажлын гүйцэтгэгчээр “Тот ком сервис” ХХК шалгарч 50,0 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн.

Мөнгөнморьт, Архуст, Баянцагаан, Сэргэлэн, Өндөрширээт сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах тендер зарлагдаад байна. Зуунмод суманд газрын дуудлага худалдаагаар зарагдсан 42 нэгж талбарын газруудад дэд бүтэц байгуулах ажлын зураг төслийг “ДНТ” ХХК-иар гүйцэтгүүлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин баригдаж байгаа 6 барилга байгууламжид захиалагчийн хяналт гүйцэтгэж байна.

Архитектур төлөвлөлтийн 11 даалгавар боловсруулан баталснаар нийт 39 архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдав.

Барилгын эх загвар болон ажлын 8 зураг төслийг хянаж зөвшөөрөл олгосноор нийт 52 барилгын зураг төсөлд зөвшөөрөл олгоод байна.

Тайлант сард 9 барилга байгууламж ашиглалтад өгсөнөөр аймгийн хэмжээнд нийт 12 барилга, байгууламж ашиглалтад орлоо.

“Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан”-д 5 барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний өгөгдлийг бүртгүүлэн ажилласан.

Газрын харилцааны үйлчилгээ: 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр 9903 иргэнд 1565,42 га газрыг өмчлүүлэхээр газрын хэмжээг тогтоосон бөгөөд 05 дугаар сарын байдлаар 843 иргэнд 96,57 га газар өмчлүүлээд байна. Аймгийн газрын төлбөрийн орлогод 188481005 төгрөг төвлөрүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн ГТ-2, ГТ-3 маягтын дагуу гаргасан тайланг баримттай тулган шинэчлэх ажлыг зохион байгуулж, гэрчилгээний Э дугаарыг судалгаанд нэмж оруулав.

Сэргэлэн сумын ландменежер программ хангамжид 2016, 2017, 2018, 2019 оны газар эзэмшил, өмчлөлийн 10000 хувийн хэргийг нөхөн бүрдүүлэх ажлыг хийсэн.

Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт Нисэх онгоцны буудлын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 12000 га газарт давхцал бүхий иргэн, аж ахуй нэгжийн судалгааг боловсруулсан. Мөн Майдар сити хотын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давахцал бүхий газар эзэмшигчдийн судалгааг гаргаж, мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Байгаль орчны чиглэлээр: Үндэсний Аялал Жуулчлалын холбооноос 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан "УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО 2019" үзэсгэлэнд аймгийн БОАЖГ-аас төлөөлөл оролцлоо.

Ойн тухай хууль тогтоожид заасны дагуу Төв аймгийн ойн сангаас 2020 онд бэлтгэх модны хуваарийн саналыг сум тус бүрээр гаргаж, Ойн судалгаа хөгжлийн төвд хүргүүлсэн.

“Ойн тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хаврын арга хэмжээг 2019 оны 05 дугаар сарын 11-ны өдөр зохион байгуулахад 231 байгууллага, аж ахуй нэгж, 4448 иргэд оролцож, том мод 18976 ширхэг, бут сөөг 20773 ширхэг, нийт 39749 ширхэг мод, бут сөөг тарьж 63.7 сая төгрөг зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд 5 дугаар сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр бүх нийтийн цэвэрлэгээнд нийт 130 аж ахуйн нэгж, байгууллага, 1878 иргэн хамрагдаж 506 тн хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж нийт 2,4 сая төгрөг зарцуулсан.

Ус хамгаалалт, ашиглалтын хүрээнд 2 байгууллагад хяналт шалгалт хийсэн.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Заамар суманд 05 дугаар сарын 20-24 ны өдрүүдэд Бичил уурхайн нөхөрлөлүүд, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 5 нөхөрлөлийн үйл ажиллагаа зогсоон лац тавьж, 1 ААН-д торгууль ногдуулж, 1 ААН-ийн үйл ажиллагааг зогсоов.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: “Баталгаажуулалтын зөвлөл”-ийн хурал 5, “Баталгаажуулалтын салбар зөвлөл”-ийн хурал 4, нийт 9 удаагийн хурал зохион байгуулав. Хүсэлт гаргасан Зуунмод, Батсүмбэр, Баян, Баян-Өнжүүл, Эрдэнэсант сумын

139 худалдаа үйлчилгээний газарт үнэлгээ хийж, 125 үйлчилгээ, бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаагаар олголоо.

Архуст, Баян, Батсүмбэр, Баянжаргалан, Баянчандмань, Борнуур, Мөнгөнморьт, Жаргалант, Сүмбэр, Сэргэлэн, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод сумын худалдаа, үйлчилгээний тооцоо, хүн, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ оношилгоонд ашиглагдаж байгаа 4372 ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгслийг ээлжит баталгаажуулалтад хамруулав.

Батсүмбэр, Баян, Баянчандмань, Эрдэнэсант сумын 67 худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд “Стандартчилал, тенхикийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоол, Төв аймгийн ИТХ-ын 8-р хуралдааны 05-р тогтоолоор батлагдсан “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын талаар мэдээлэл хийсэн.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, аймгаас “Залуучуудын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт, мөн “Төв соёл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, “Сонгодог урлаг-III ” аймгийн дэд хөтөлбөрийг хэлэлцүүлж, батлууллаа.

2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Төв аймгийн Засаг дарга, Монгол Улсын Боловсролын их сургуулийн ректор Д.Мандах нар 17 чиглэлээр хамтран ажиллах гэрээг байгуулж, 12 сумын ЕБС-д 38.0 сая төгрөгийн өртөг бүхий Физикийн хичээлийн 60 багц тоног төхөөрөмжийг нийлүүлэв.

“Эрүүл хүүхэд” аяны хүрээнд Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 7.6 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн шүдний төхөөрөмж олгох санхүүжилтийг шийдвэрлэсэн.

“Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-т тусгагдсаны дагуу “Зөв бичих дүрэм, журамласан үг”-ийн сургалтыг 23 байгууллагын 115 төрийн албан хаагчийн хамруулан зохион байгууллаа.

Аймгийн ГБХЗХГ-тай хамтран 7 сумын 212 сурагчтай цахим хэлбэрээ “Хүүхдээ сонсох” өдөр зохион байгууллаа. Мөн Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнээс бүтэн өнчин 58 хүүхдэд хувцас, гарын бэлэг гардуулсан.

ЕБС-ийн шилдэг сурагчдын төлөөлөл болсон 27 сумын 148 сурагчид “Амжилтын Од” медаль гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулав.

Монгол улсын Төрөөс баримтлах соёлын бодлогын хүрээнд УДЭТ-ын өдрийг МТГ-т 05 дугаар сарын 16-19-нд зохион байгуулж, 5 удаагийн тоглолтыг иргэдэд толилуулсан.

АНУ-ын Элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албанаас хүсэлт ирүүлсний дагуу аймгийн Монгол Туургатан театрын уран бүтээлч нартай АНУ-ын “ABERDEEN” рок хамтлагийн гишүүдтэй уулзалт хийж, харилцан туршлага судаллаа.

Аймгийн хэмжээнд сагсан бөмбөгийн хөгжлийн “лиг”-ийн тэмцээнийг анх удаа зохион байгуулж, нийт 8 багийн 120 тамирчин оролцож байна. Эхний улиралд 56 тоглолт 7 хоног бүрийн Лхагва, Баасан гарагуудад хуваарийн дагуу явагдана.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 95 дугаар зарлигаар Төв аймгийн хэмжээнд “Эхийн алдар-I” одонгоор 34, “Эхийн алдар-II” одонгоор 409, нийт 443 ээж шагнагдаж, 05 дугаар сарын 30-ны өдөр Зуунмод сумын 6 багийн 54 ээжид одон гардуулах ажлыг зохион байгуулав.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: 2019 оны 05 дугаар сарын 13-нд “Би багш” шоу нэвтрүүлгийн шалгаруулалтыг зохион байгуулсан. Шалгаруулалтад 18

сургуулийн 28 багш оролцож, удирдамжид тусгагдсан 5P загварын дагуу үнэлж, 3 багшийг тодрууллаа.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч багштай хамтран Хүмүүн, Зуунмод-IV, Батсүмбэр сумын ЕБС-ийн сургуулийн “STEM” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, явц үр дүнд дүгнэлт хийж, чиглэл, зөвлөмж өгч ажилласан байна.

Сурагчдад эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх, орос хэлний мэдлэгийг дээшлүүлэх, Монгол-Оросын найрамдал нөхөрлөл хамтын ажиллагаа, түүх соёл уламжлалаас суралцах зорилгоор “Халх гол”-ын тулалдааны түүхт 80 жил, Аугаа их эх орны дайны Ялалтын 74 жилийн ойг угтсан арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 30 сургуулийн 27 багш 780 гаруй сурагчид оролцлоо.

ЭЕШ-д бэлтгэх зорилгоор 12 жилийн сургалттай 7 сургуулийн 120 сурагч, 30 сургуулийн 55 багшаас 2 удаагийн сорил шалгалт авч, дүн мэдээг нэгтгэн дүгнэлт зөвлөмж хүргүүлээд байна.

Театрын үйлчилгээ: “Малчин” телевиз, “Монос” групп, Бүрэн сум болон аймгийн төрийн 5 байгууллагатай хамтран 7 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 1120 иргэнд үйлчлэв.

МУГЖ Б. Сарантуяагийн “Амьдрал” тоглолтоор 400; УДЭТ-ын “Бүсгүйн зурвас”, “Надаар тоглосон хайр”, “Би эндээс явахгүй”, “Бардам туулай” тоглолтоор 2400, нийт 2800 үзэгчид үйлчиллээ.

Мөн Монгол туургатан театр “Facebook од” хүүхдийн жүжиг, дуу ангийн уран бүтээлчид “Дуун болзоо” уран бүтээлийн тоглолтоор Эрдэнэсант, Баяндэлгэр суманд, Монгол туургатан театрын дуучин МУСТА П.Баярмагнай, жүжигчин Р.Янжиндулам нарын хамтарсан уран бүтээлийн VIP тоглолтыг Улаанбаатар хотод тус тус зохион байгуулж, нийт 820 үзэгчдэд үйлчилсэн байна.

2019 оны 05 дугаар сард нийт 4120 үзэгчдэд үйлчилж, 4.474.000 төгрөгийн орлого оруулав.

Музейн үйлчилгээ: Тайлант сард 1479 үзэгчид үйлчилж, 869000 төгрөгийн орлого төвлөрүүлээ.

Иргэд, хүүхэд залууст зориулсан танин мэдэхүй, боловсролын ажлын хүрээнд “Соёлын өв бидний бахархал” сэдэвт илтгэлийн уралдаан, уулзалтыг 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Зуунмод ЕБ-ын 4, 5 дугаар сургууль, Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн 35 сурагч, түүх, нийгмийн ухааны багш нар оролцов.

Олон улсын Музейн өдрийг угтаж Монгол улсад банк санхүүгийн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойд зориулсан “Монгол Улсын зоос, мөнгөн тэмдэгт (1925-2017)” сэдэвчилсэн үзэсгэлэнг зохион байгууллаа.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: 2019 оны 5 дугаар сард 410 байнгын уншигч, 1342 ирэгсэд, нийт 1752 уншигчдад 3917 ном олгож уншуулсан.

“Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан “Үндэсний бичиг, бидний бахархал” номын үзэсгэлэн, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хүүхдийн ертөнц” номын үзэсгэлэнг тус тус зохион байгууллаа. “Уншлагыг дэмжье” аяны хүрээнд 2 цэцэрлэгийн 60 хүүхэд багачууд, эцэг эхэд Номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, үлгэрийн цагаар аялуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч үйлчлэх ажлын хүрээнд 1-р баг, хараагүйчүүдийн төвөөс судалгааг авч тэдэнд зориулсан “DAISY” номыг гэрээр олгож үйлчиллээ.

Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдэд үйлчлэх тоо, чанарыг ахиулахын тулд Аргалант, Баянцагаан, Баянцогт сумын Соёлын төвтэй хамтран 9 багийн 122 иргэнд 181 номоор, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 324 иргэнд 450 номоор, нийт 446 иргэнд 631 ном олгон уншуулав.

Нийтийн номын сангийн үндсэн фондонд хадгалагдаж буй 2010-2019 оны “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг улирлаар нь багцалж 43 нэгж болгосноор иргэд, уншигчдын мэдээлэл авах шуурхай байдлыг бүрдүүллээ.

Биений тамир, спортын үйлчилгээ: Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Төвийн бүсийн аймгуудын БТС-ын ажилчдын “Спорт ба хөгжил сэдэвт” сургалт зөвлөгөөнд аймгаас 11 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

“KOICA” олон улсын байгууллагаас ширээний теннис, жудо, фитнес, нийтийн биений тамирын чиглэлээр мэргэжилтэн багш нар ажиллахаар боллоо.

Зохион байгуулсан уралдаан тэмцээн: 1. Даатгуулагчдын өдрийг угтаж аймгийн Нийгмийн даатгалыни хэлтсээс уламжлал болгон зохион байгуулагддаг “волейбол”-ын тэмцээнд 27 багийн 162 тамирчин оролцсон.

2. Масристенгийн улсын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд 2 улсын 15 байгууллагын 121 тамирчин оролцлоо. Тус тэмцээнд ОХУ-ын Саха Якут улсаас 11 тамирчин оролцсон байна.

3. Хүүхдийн спортын VI их наадмын хүрээнд уулын дугуйн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад Эрдэнэ, Жаргалант, Архуст, Заамар, Борнуур, 5-р сургууль, Батсүмбэр, Баянчандмань сумдын 37 тамирчин 3 насны ангилалд оролцлоо.

4. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнд 21 сумын 27 багийн 340 хүүхэд багачууд оролцсон.

5. Төв Ургац сагсан бөмбөгийн холбооны ерөнхий дасгалжуулагч, сагсан бөмбөгийн спортын мастер Д.Эрдэнэбаатар агсны нэрэмжит насанд хүрэгчдийн сагсан бөмбөгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 231 тамирчин оролцлоо.

6. Нийгмийн эрүүл мэндийн өдрийн хүрээнд “Нарны алхалт” арга хэмжээг 5 дугаар сард 3 удаа зохион явуулж 1200 хүнийг хамруулсан байна.

Аймгийн баг, тамирчдын оролцсон уралдаан, тэмцээн: 1. Багануурын цом-2019 жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож 3 алт, 6 мөнгө, 7 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр хүрэл медаль хүртлээ.

2. ЗХУ-ын Баатар Д.Жанаевийн нэрэмжит 43 дэх удаагийн чөлөөт бөхийн тэмцээнд ОХУ, МОНГОЛ КАЗАКСТАНЫ 50 гаруй багийн 650 тамирчин өрсөлдсөнөөс Төв аймгийн Чөлөөт бөхийн Өсвөр үеийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцон 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.

3. Орхон аймагт зохион байгуулагдсан төвийн бүсийн аварга шалгаруулах таеквондогийн тэмцээнд Төв аймгийн “Эв нэгдэл” клубын тамирчид 1 алт, 3 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/149 дугаар тушаалаар “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж 920 иргэнд үйл ажиллагааны талаар мэдээлэл, 14 иргэнд угийн бичиг хөтлөх арга зүйн зөвлөгөө, хүүхэд хөгжлийн 4 төрлийн дугуйлангийн талаар танилцуулж, шинээр 15 хүүхэд элсүүлж, 1 иргэнд хүүхдийн эрхийн зөрчлийн зөвлөгөө өгч, 7 төрлийн 1115 гарын авлага, тараах материалыг тараан, санал хүсэлтийн хайрцаг ажиллуулсан.

2019 оны 05 сарын 03-04 өдрүүдэд “Яргуй-2019” хүүхдийн урлагийн бага наадмыг зохион байгуулахад 27 сумын 460 хүүхэд хамрагдлаа.

Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, ахлах ангийн сурагчдад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын 1 сарын аяныг 3 дахь жилдээ зохион байгуулж байна. Аяны хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ” лекц зохион

байгуулж, Зуунмод сумын ЕБС-ийн 9-р ангийн 250 сурагчийг хамруулсан. Мөн Зуунмод сумын МСҮТ-тэй хамтран “Мэргэжил бүхэн сайхан” өдөрлөгийг 05 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд зохион байгуулахад Зуунмод сумын ерөнхий боловсролын 3 сургуулийн 248 сурагч хамрагдаж, мэдээлэл зөвлөгөө авсан.

Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, тогтвортой байдлыг хангах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, эцэг эхчүүдэд хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх хандлагыг төлөвшүүлэх, “Гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдаж байгаа өрхийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “ХҮМҮҮЖЛИЙН ЭЕРЭГ АРГАД НЭГДЬЕ” өдөрлөгийг 17 сумын 219 өрхийн тэргүүн, гэр бүлийн оролцуулан зохион байгуулсан. Арга хэмжээний зардалд 3.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Монгол улсын Их Хурлын гишүүн М.Энхболдын ивээл дор “Иргэний андгай” өргөх ёслолын арга хэмжээг Зуунмод суманд 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулахад 120 сурагч оролцож, иргэний үнэмлэхээ гардан авлаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2019 оны 5 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ 1816 иргэнд 1515.7 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1139 иргэнд 412.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 994 иргэнд 332.4 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 652 ахмад настанд 102.9 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 354 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 39.4 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 1213 эхэд 158.8 сая төгрөгийн тэтгэмж олголоо.

Алдарт эхийн одонтой 8919 эхэд 1200.0 сая төгрөг, алдар цолтой 59 ахмад настанд 48.1 сая төгрөг, 4871 ахмад настанд 400.6 сая төгрөгийн насны хишгийг олгож, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 5143 эхэд 1203.0 сая төгрөгийн тэтгэмж, 3 ба түүнээс дээш тооны 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон 262 эх /эцэг/-т 82.4 сая төгрөгийн тэтгэмж олгов.

Өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй 28896 хүүхдэд 577 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

ХБИ-ийг ажлын байраар хангах ажлын хүрээнд ОУ-ын НОШБуудалд шинээр 2, ЭМТ-д 1 иргэн байнгын ажлын байраар хангагдлаа. Аймгийн хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй 245 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 3211 иргэн, хөдөлмөр эрхэлж буй 565 иргэний судалгааг гаргасан. ХБХЭМБНХСКомисс 2 удаа хуралдаж, хөгжлийн бэрхшээлтэй 22 хүүхдийг байнгын асаргаатай болохыг тогтоож, СӨБ, ЕБС, Тусгай сургуульд 4 хүүхдийг хамруулж, 2 хүүхдийг ХБ-тэй болохыг тодорхойлсон.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 74 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 34 ажил олгогч байгууллага, 75 сул ажлын байр, 40 ажилд зуучлагдсан иргэн, 101 шинэ ажлын байрыг бий болгосон байна.

Байгалийн давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас үүссэн хохирлыг арилгах буюу зарим сумын нутагт үлийн цагаан оготно устгах ажлаар нийтийг хамарсан ажлыг 16 суманд зохион байгуулж 187 иргэнийг 5 хоног ажиллуулж, 36.1 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс олголлоо.

Аж ахуй эрхлэх хүсэлтэй бизнес эрхлэгч болон ажил хайгч иргэдийн хүсэлтэд үндэслэн Эрдэнэ МСҮТ, Футур сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулж, 10 сумын 238 иргэнд “Жижиг зээлийн төслийг боловсруулах сургалт”, 8 сумын 59 иргэнд “Бүлгийн сургалт”-ыг зохион байгуулсан бөгөөд сургалтын зардалд ХЭДСангаас 4.4 сая төгрөг зарцуулсан.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 15 сумын 24 иргэн, ХХЭ-тэй 33 ажлын байр шинээр бий болгох гэрээ байгуулж, 9.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг ХЭДСангаас олгохоор шийдвэрлэсэн. АБДХ-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 2017-2018 онд хамрагдсан 4 иргэнд түрээсийн төлбөрийн хөнгөлөлт олгож, 744,0 мян.төг-

ийн дэмжлэг үзүүлсэн. 2 иргэнийг байнгын ажлын байраар хангасан Монгол шуудан ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХК-д нийт 5.9 сая төгрөгийн урамшуулал олгогдсон.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд: Малжуулах арга хэмжээнд 15 сумын 44 малчинд 205.0 сая төгрөгийн мал хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд: Ахмад мэргэжилтний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны 7 төсөлд 15.5 сая төгрөгийг санхүүжүүлж, 13 ахмад мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

ХБИ-ний ХЭД хөтөлбөрийн хүрээнд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 8 төсөлд 25.0 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.

ХЭДС-ийн төсөл, жижиг зээлд хамрагдсан өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах зорилгоор “Дэлхийн зөн” ОУБ-тай хамтран “Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн 3-р зөвлөгөөн-сургалт”-ыг 2019.05.27-28-ны өдрүүдэд Алтанбулаг суманд зохион байгууллаа.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах” комисс нь эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээг иргэдэд ойртуулж, тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор Жаргалант, Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Сүмбэр сумдыг оролцуулан 2019.05.24-ний өдрөөс 2018.05.26-ны өдрүүдэд “Нүүдлийн хурал” зохион байгуулж, 66 даатгуулагчийн хөдөлмөр чадвар алдалтын байдалд зохицуулалт хийлээ. Комисс хурлыг тайлан хугацаанд 5 удаа зохион байгуулж, 323 иргэний асуудлыг хэлэлцэв.

Аймгийн хэмжээний 13758 тэтгэвэр авагчдад 5 дугаар сард 4.7 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгож, 132 даатгуулагчид 132,4 сая төгрөгийг тэтгэмж олгосон.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Геронтологийн үндэсний төвтэй хамтран “Геронтологи, гериатрын үндсэн ойлголт, орчин үеийн оношилгоо, эмчилгээний чиг хандлага” сэдэвт онол, дадлага хосолсон сургалтыг 05 дугаар сарын 15-16-нд зохион байгуулж 60 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа. Мөн 70 гаруй ахмадуудад “Насжилт, эрүүл мэндийн менежмент, өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлага”, “Нойргүйдлийн тухай ойлголт”, “Эмийн зохистой хэрэглээ” сэдвүүдээр сургалт, зөвлөгөө өгөв.

МУЗН ҮХБ-ын Төв аймаг дахь салбартай хамтран “**Анхны тусламж-Амь нас аварна**” сэдэвт сургалтыг “Тэнүүн гэрэл констракшн” ХХК-ны ажилчдад зохион байгуулж, анхан шатны эрүүл мэндийн тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлсэн.

Өндөрширээт, Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв, “Мөнхжин” сувилал, “Замтын булаг” сувиллыг магадлан итгэмжлэлд хамруулав.

Олон улсын сувилагчийн өдрийг угтан “Сувилахуйн алдартан-2019”, Бүсийн 4 төрөлт тэмцээн “Бүтээлч аян”-ыг тус тус зохион байгуулахад 32 эрүүл мэндийн байгууллагын 43 сувилахуйн баг оролцов.

2018-2019 оны хичээлийн жилд аймаг, орон нутагт анх удаа “Сувилахуйн шаталсан бакалаврын анги”-ийг нээж, улмаар 11 оюутан бакалаврын боловсролтой боллоо.

Боомын хяналтын шинжилгээг Зуунмод, Лүн, Аргалант, Баянцогт, Эрдэнэ суманд үйл ажиллагаа явуулж буй мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эдийн худалдаа үйлчилгээ эрхэлж буй аж ахуй нэгж, иргэдэд хийсэн. Тандалт шинжилгээгээр 150 иргэнээс боом өвчний мэдлэг хандлага тодорхойлох асуумж судалгааг авч, зөвлөмж мэдээлэл хүргэн 300 ширхэг гарын авлага тараав. Боом өвчний хяналтын шинжилгээнд 4 нэр төрлийн 182 сорьцыг авч Зооноз өвчин судалын лабораторид хүргүүлээ.

Дархлаажуулалтын 10 хоногийг “**УЛААНБУРХАН ӨВЧИНД ЦЭГ ТАВЬЯ**” уриан дор явуулж, 10-18 насны хүүхдийг вакцинаар дархлаажуулах ажлыг 2019 оны 05 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд зохион байгуулахад хамрагдалт 87,5 хувьтай байна.

Сүмбэр сумын ЕБС-ийн багш, сурагч сүрьеэгээр өвчилж, индекс тохиолдол бүртгэгдсэн тул хариу арга хэмжээг ХӨСҮТ-тэй хамтран хэрэгжүүлэв. 5 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд сургуулийн багш, сурагчид, сүрьеэтэй өвчтөний хавьтлын 433 хүнийг рентген шинжилгээнд, 287 сурагч, 37 багш ажилтанд туберкулины арьсны сорил тавьсан. Сорил өндөр гарсан 192 хүүхдийн цээжний зургийг уншиж, 14 хүүхдийг давтан шинжилгээнд хамруулж, шинээр 27 хүүхдийг сүрьеэгийн эмчилгээнд, 158 хүүхдийг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулсан.

“Баруун-Зуунмод” өрхийн ЭМТ, Монос групптэй хамтран “Монос таныг зориод ирлээ” эрүүл мэндийн өдөрлөгийг зохион байгуулахад давхардсан тоогоор 800 гаруй иргэд 6 төрлийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдсан байна.

2019 оны 05 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд “Зүрхний дутагдлын 7 хоног”, 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Unimed” эмнэлэгтэй хамтран “Үргүйдэл” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан. “Denk pharma”, Зүрх судасны төвтэй хамтран 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Зүрхний дутагдлын талаарх иргэдэд зориулсан өдөрлөг” зохион байгуулж, 73 иргэнд цусан дахь сахар, артерийн даралт, пүлс хэмжиж, эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.

НҮБ-ын хүн амын сангийн 12.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Happy health the life” төслийг хэрэгжүүлэн Нэгдсэн эмнэлгийн өсвөр үеийн кабинетыг тохижуулав.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлого: Татварын орлого бүрдүүлэлтийн ажил эрчимжүүлэх 2 сарын аяныг үр дүнд 3-р сарын аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 102,8 хувь буюу 102 сая төгрөгөөр давж биелсэн.

Аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөө 2019 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 5752,6 сая төгрөг оруулахаас 5455,8 сая төгрөг оруулснаар 296,8 сая төгрөг буюу 94,8 хувиар тасарсан. Үүнд цалингийн ашгийн албан татвар, ҮХЭХ-ийн орлого, ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Алтанбулаг, Баян, Баянжаргалан, Заамар, Борнуур, Лүн, Сэргэлэн сумд биелүүлээгүй байна.

Сумдын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 129,3 хувь буюу 305,9 сая төгрөгөөр давж биелэсэн байна. Сумдын төсвийн орлого давж биелэхэд үйл ажиллагааны орлого 87,7 сая төгрөг, хадгаламжийн хүүгийн орлого 88.1 сая төгрөг, ҮХЭХ борлуулсаны албан татвар 16.1 сая төгрөг, Хог хаягдлын хураамжийн орлогоор 10,5 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр 6.4 сая төгрөг, хүү торгуулийн орлого 62,5 сая төгрөг, бусад орлого 34,6 сая төгрөгөөр тус тус давж биелэсэн нь нөлөөлжээ. Баян, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Зуунмод сумд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тасалдуулсан. .

Төсвийн зарлага: Сумдад эхний 05 сарын 29-ний байдлаар өссөн дүнгээр нийт 27.983.397,1 мянган төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон бөгөөд салбараар нь танилцуулбал:

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 13.961.912,2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 9.592.732,5 мянган төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 4.369.179,7 мянган төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 3.543.367,0 мянган төгрөгийг олгосон. Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 3.442.254,3 мянган төгрөг

-Өрхийн эмнэлэгт 101.112,7 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 193.687,1 мянган төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 117.472,4 мянган төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 10.166.958,4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 6.825811,0 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 3.341.147,4 мянган төгрөг

-ОНХСангуудад 1.143.647,3 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлага: 2019 оны 5 дугаар сарын ХБГ-ээр сумд болон төсөвт байгууллагууд нийт 112375,6 мянган төгрөгийн авлага, 676969,3 мянган төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 495782,4 мянган төгрөг буюу 73,2 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 61061,1 мянган төгрөг буюу 9,0 хувь нь цалингийн өглөг, 19656,2 мянган төгрөг буюу 2,9 хувь нь НДШ-ийн өр, 36581,4 мянган төгрөг буюу 5,4 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 27650,8 мянган төгрөг буюу 4,1 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 36237.4 мянган төгрөг буюу 5.4 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Аймгийн Засаг даргын нэрэмжит VI удаагийн үзлэгийг 27 сум, 22 агентлаг, 5 байгууллагад зохион байгуулж, дүнг нэгтгэж Засаг даргын Зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 23-ны хурлаар хэлэлцүүлсэн.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

2019 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 27-ны өдрүүдэд хөдөөгийн 14 суманд; нэгдсэн татлагыг 05 дугаар сарын 01-ний өдөр Зуунмод суманд зохион явуулж Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн төв дамжингийн үзлэгээр оруулснаар хяналтын тоог 100 хувь биелүүлэв. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 56 иргэнтэй гэрээ байгууллаа.

Халх голын ялалтын 80 жилийн ойг тохиолдуулан хүүхэд залуучуудыг эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлэх, тэдний бие бялдрын түвшинг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын баатар Д.Самдангийн нэрэмжит цэрэг спортын “Дөл-2019” аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг ЕБ-ын 6 сургуулийн ахлах ангийн 70 гаруй сурагчдын дунд 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдөр амжилттай зохион явуулсан. Зүүн бүсийн аварга шалгаруулах цэрэг спортын ДӨЛ-2019 тэмцээнд “Хүмүүн” цогцолбор ЕБС-ийн баг, тамирчид амжилттай оролцож тусгай байрын шагнал авсан.

2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр "Монгол цэрэг -Дэлхийн цэрэг" сэдэвт уулзалт ярилцлагыг Зуунмод сумын Ерөнхий боловсролын 3 сургуулийн 100 гаруй сурагчдын дунд явуулж, Зэвсэгт хүчний 016 дугаар бригадын үйл ажиллагаатай танилцуулав.